



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/264

Булган сум

“Жигүүр-1”, “Жигүүр-2” хамтлагийн тэмцээн уралдааны зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад наснуудын дунд зохион байгуулагдах “Шугаман бүжгийн улсын аварга” шалгаруулах 2 дугаар шатны шалгаруулалтад оролцох болзол хангасан Булган сумын “Жигүүр-1”, “Жигүүр-2” хамтлагийн тэмцээн уралдааны зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлын Ахмад настны хөгжил хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ